



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/А/

Дэлгэрмөрөн

Томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Онцгой комиссын 2022 оны 04/09 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 30 ны А/190 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, сумын хэмжээнд томуу, томуу төст өвчлөл ихсэж (бага насны хүүхэд) хүндрэх эрсдэл өндөр байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх Боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 4 дүгээр сарын 8-ний өдөр хүртэл ажлын 7 хоног түр хугацаагаар зогсоож халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсүгэй.

2.Ерөнхий боловсролын сургуулийн халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлуулж, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Сургуулийн захирал (Б.Ууганбаяр) –д,

3.Сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлаж байгаатай уялдуулан анги танхимын ариутгал халдваргүйжилтийг хийж, цахимаар сургалтын үйл ажиллагааг явуулахыг Цэцэрлэгийн эрхлэгч (Я. Оюунчимэг) – д,

4.Эрүүл мэндийн төвд нэмэлтээр дэлгэх ор, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, Эрүүл мэндийн төвийн бэлэн байдлыг хангаж, өвчлөлийн халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар сурталчилгаа, мэдээ, мэдээлэл, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Дорждагва), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Zahiramj -2022 on

• 642201033

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)- д даалгасугай.

ДАРГА *Сумъяабазар* С.СУМЪЯАБАЗАР

A red rectangular official stamp of the Ministry of Justice of Mongolia. The stamp contains the Mongolian text "МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗАСАГ" (Law of Mongolia) and "ХУУЛЬ ЗАСАГ" (Law). A signature in cursive script is written over the stamp, and the name "С.СУМЪЯАБАЗАР" is printed to the right of the stamp.